

**“ХӨВСГӨЛ ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2018-04-17

Мөрөн

Хурал: Хөвсгөл аймаг Мөрөн сумын 8-р багт байрлах “Хөвсгөл Хүнс”ХК-ийн өөрийн хурлын зааланд 2018 оны 04-р сарын 17-ны өдрийн 17.00 цагт эхлэв.

Хурлын ирцийг “Хөвсгөл Хүнс” ХКомпанийн ТУЗ-ийн Хурлын дарга Л.Дашцэрэн ирцийг 85.5 хувь байгааг мэдэгдэж хурлыг нээж.

Хурлаар хэлэлцэх асуудлууд, хурлын дэгийг танилцуулав.

- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
- Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан
- Компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөг батлах
- Хянан шалгах зөвлөлийн тайлан
- ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
- Компанийн ТУЗ-ийг сонгох
- Ногдол ашиг тараах эсэх

Хурлын дарга Л.Дашцэрэн- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулав.

Ерөнхий нягтлан бодогч Л.Тэгшбаяр- Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт

Гүйцэтгэх захирал Л.Цэрэнжав- Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан

- Компанийн 2018 оны бизнес төлөвлөгөө
- Компанийн ТУЗ-ийг сонгох талар хэлэлцүүлэв.

Ерөнхий нягтлан бодогч Л.Тэгшбаяр - Хянан шалгах зөвлөлийн тайлан

- ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
- Ногдол ашиг тараах эсэх асуудлыг хэлэлцүүлж санал хураалт явуулав.

2017 онд улс орны эдийн засгийн нөхцөл байдал хүнд хямралтай ард иргэдийн гар дээр бэлэн мөнгө ховор худалдан авалт огцом буурсан компани ашиггүй ажилласан тул ногдол ашиг тараах боломжгүй байна.

За дээрхи асуудлуудтай холбоотой санал хүсэлт байна уу?

Тооллогын комиссын дүнг тооллогын комиссын дарга Ж.Алтангэрэл-
Тооллогын комиссын дүнг танилцуулав.

Хурлын дарга Л.Дашцэрэн- Тооллогын комиссын дүнг үндэслэн тогтоолын төслүүдийг батлуулж уншиж танилцуулав.

Гүйцэтгэх захирал- Л.Цэрэнжав - 2017 онд талх нарийн боовны сав баглаа боодлыг шинэчлэн сайжруулж шинэ савлагаатай болголоо. Ингэснээр нарийн боовны өнгө үзэмж сайжирч хэрэглэгчийн худалдан авах түвшинд дээшилсэн. 2018 онд компанийг ашигтай ажиллуулах тал дээр анхаарч бизнес төлөвлөгөөнд зарим зүйлүүдийг тусгасан.

Мөн нөөшилсөн бүтээгдэхүүний цехийн тасралтгүй ажиллагааг хангах жилийн дөрвөн улиралд үйлдвэрлэл явуулдаг байх адуу үхрийн мах нөөшлөх хатаах зэрэг бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах зах зээлд нэвтрэх тал дээр анхаарч ажиллаж байна. Манай компани нь 2018 онд сургууль цэцэрлэгийн 200 гаруй сая төгрөгийн тендерт шалгараад байна. Мөн энэ 6-р сард багтаан Хөвсгөл нуурын хаянд Хатгал тосгонд цэвэр усны үйлдвэрийг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул хурлыг 18.30 минутад хаав.

ТАНИЛЦСАН: ТУЗ-ИЙН ДАРГА **ХӨВСГӨЛ ХУИС** Л.ДАШЦЭРЭН
ХК

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН: **ХӨВСГӨЛ ХУИС** С.ОТГОНБААТАР
6718262419

